



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Бууцагаан сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** БНА-2019/6/СТА-ТТЗ

Баянхонгор  
2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576      Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 88089024      Цахим хаяг: tsetsegmaadam@audit.gov.mn

Ахлах аудитор:                      А.Цээням

Утас: 99442140      Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

<b>Агуулга</b>	
1	Аудитын гэрчилгээ ..... 3
2	Аудитын тайлан ..... 5
2.1.	Оршил ..... 5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ..... 5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт ..... 6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ..... 6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ..... 8
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал..... 9
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар ..... 9
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн..... 9
2.8.1	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар ..... 10
2.8.2	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар..... 12
2.8.2.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал: ..... 13
2.8.2.1	Төлбөрийн акт тогтоосон зөрчилтэй асуудал: ..... 13
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал . 13
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ..... 13
2.11.	Шилэн дансны мэдээлэл ..... 14
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга ..... 14
2.13.	Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл: ..... 14
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл..... 15
3	Менежментийн захидал..... 16
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан ..... 17

## 1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум  
Утас, факс 70-44-25-84  
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2019.03.22 № 2/144  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т  
Г Аудитын гэрчилгээ Г

Г БУУЦАГААН СУМЫН ЗАСАГ  
ДАРГА Ж.АЛТАНЦЭЦЭГ ТАНАА Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Бууцагаан сумын Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Бууцагаан сумын Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Бууцагаан сумын Засаг даргын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

C:\Users\Dell\Desktop\Бууцагаан ТЕЗ гэрчилгээ.docx

2519279

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### Үүрэг хариуцлага

Бууцагаан сумын Засаг дарга нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

C:\Users\Dell\Desktop\Бууцагаан ТЕЗ гэрчилгээ.docx

## **2 Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Бууцагаан сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч сумын Засаг дарга Ж. Алтанцэцэгт танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтыг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2,3-д заасны дагуу Бууцагаан сумын Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бууцагаан сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 03 дугаар сарын 11-нээс 2019 оны 03 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, БНА-2019/06/СТА-ТТЗ

Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын ахлах аудитор А.Цээням хариуцаж хэрэгжүүлэв.

Бууцагаан сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2018 оны 12 дугаар сарын 20 -ны өдрийн 2/267 тоот албан бичгээр 2019 оны 3 дугаар сарын 05-ны өдөр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Бууцагаан сумын Засаг даргын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Бууцагаан сумын Засаг дарга нь “ 2018 онд эх нутаг, уул усаа шүтэж төрийн хуулиа дээдэлсэн эрүүл, оюунлаг, бүтээлч, чинээлэг иргэнтэй байгаль орчины тэнцвэрт байдлыг хангахуйц дэд бүтэц, жижиг дунд үйлдвэр үйлчилгээ, аялал жуулчлал эрсдэлгүй эдийн засагтай бүс нутгийнхаа хөгжил хандлагыг тодорхойлсон жишиг сум болно” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Бууцагаан сумын Засаг даргын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүнд суртал чирэгдэлгүй хүргэж, иргэд эрүүл аюулгүй орчинд амьдрах тэдний амьдрал ахуйг сайжруулах үүднээс шинээр ажлын байруудыг бий болгож орлогыг нь нэмэгдүүлэх төрөөс үзүүлэх үйлчилгээ чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд оршино гэсэн зорилт дэвшүүлэн доорх ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Манай сум халдварт өвчингүй сум болох зорилт тавьж УБ хотоос эрүүл мэндийн лабораторийн шинжилгээний нарийн мэргэжлийн эмч нарын баг ирж 124 иргэний элэгний үйл ажиллагаа, бөөрний үйл ажиллагаа, цусны ерөнхий шинжилгээнд хамруулж ЭХО, дотор, зүрх судасны үзлэг, оношлогоо зохион байгуулсан.

- Багийн төвүүдийг эрчим хүчээр хангах ажлыг эхлүүлсэн

- Сумын хуучин сургууль, дотуур байрыг дулаанаар хангаж 70 гаруй иргэнд амьдрах болон ажлын байрны зориулалтаар олгосон

- Онцгой байдлын тусгай ангитай болов.

- Махны үйлдвэр ашиглалтад оруулж сумын малчдын малыг өндөр үнээр борлуулав.

- Төвийн 04 шугамын АСС утсыг СИП-ээр сольж хүчдэл уналтыг багасгасан зэрэг ажлуудыг хийж 2018 оны зорилгоо биелүүлэв.

Бууцагаан сумын Засаг даргын удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Захиргааны ерөнхий хууль
- Засаг захиргаа нутаг, дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 8 байгууллага, 2 тусгай сан нэгж 2018 оны санхүүгийн тайландаа аудит хийж баталгаажуулахаас 10 байгууллага аудитад хамрагдсан байна.

Төрийн аудитын байгууллагаас Бууцагаан сумын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

№	Байгууллагын ангилал	Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр				
		Санал дүгнэлт гаргасан	Түүвэрлэсэн	Итгэл үзүүлсэн	Гэрээгээр хийлгэсэн	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч	5	3	-	2	-
	Дүн	5	3	-	2	-

## 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Бууцагаан сумын Засаг даргын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Бууцагаан сумын Засаг даргын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа бүртгэл мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд 41 буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Бууцагаан сумын Засаг даргын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн Засгийн газрын санхүүгийн "Э-тайлан" программ хангамж ашигладаг байна.

Бууцагаан сумын Засаг даргын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Бууцагаан сумын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагын санхүүгийн тайланд хяналт шалгалт хийгээгүй харин Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийсэн байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Бууцагаан сумын Засаг даргын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 4 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нэгтгэсэн санхүүгийн тайлангийн хувьд байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзсэнтэй холбоотой юм.

Бууцагаан сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 5611370,9 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 56113,7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн материаллаг биш боловч цаашид санхүүгийн тайлан, тодруулгад материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй зарим асуудлыг толилуулж байна.

Бууцагаан сумын Засаг даргын болон төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагчийн хэмжээнд 5 байгууллагын тайланд зөрчил илэрч 13947,5 мянган төгрөгийн төлбөрийн акт , 82925,3 мянган төгрөгийн зөрчил арилгах 4 заалт бүхий зөвлөмж өгсөн ба мөн 3 байгууллагын санхүүгийн тайланд 50627,3 мянган төгрөгийн алдаа илэрч аудитын явцад залруулсан байна.

Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудлыг хэрхэн ангилж, шийдвэрлэсэн байдлыг энэ тайлангийн 2.13-т нэгтгэсэн байдлаар үзүүлэв.

Асуудлыг өмнөх түвшинд хийсэн аудитын явцад гарсан асуудал, төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад түүвэрт хамрагдсан асуудлаас илэрсэн асуудал гэсэн ангиллаар үзүүлэв. Үүнд:

2.8.1 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар

**Асуудал 1:** Бууцагаан сумын ЕБС нь 2018 оны 6 сард 23 ажилтны цалин, амралтын цалингаас даатгуулагчийн төлөх НДШ-ийг 11 хувиар тооцоогүй тус тус 211,2 мянган төгрөгийг суутган авч, цалинг НДХ-т 6,7-р сард хувааж мэдээлснээс шимтгэлийн 1636,3 мянган төгрөгийг дутуу суутгасан байна.

**Шийдэл:** Төлбөрийн акт тогтоосон

**Асуудал 2:** Бууцагаан сумын ЕБС батлагдсан орон тоог батлагдсан орон тооноос 3 орон тоогоор илүү ажиллаж 19544,8 мянган төгрөгийн цалин олгож 15900,0 мянган төгрөгийн цалин нийгмийн даатгалын шимтгэлийг бусад зардлаас шилжүүлэн зарцуулсан ч төсвийн хэлбэлзлийг засаагүй байна.

**Шийдэл:** Зөвлөмж өгсөн

**Асуудал 3:** Бууцагаан сумын ИТХ нь олон нийтийн байцаагч Б.Пүрэвдоржийн цалингийн мэдээллийг санхүүгийн программд даатгуулагчийн төрлийг буруу сонгож НДШ-ийг даатгуулагчаас сар бүр 2 хувиар тооцон суутгаснаас цалингаас 2018 онд шимтгэлийн 230,2 мянган төгрөгийг дутуу, цалингийн ашгийн 10,2 мянган төгрөгийг илүү суутгасан байна.

**Шийдэл:** Төлбөрийн акт тогтоосон

**Асуудал 4:** Бууцагаан сумын ИТХ 2018 оны 12-р сарын НДХ-т 3 ажилтаны цалинг тооцсон цалингаас 256,0 мянган төгрөгөөр илүү мэдээлж, НДШ-ийн төлөлтийн тайлан буруу илэрхийлэгдэж оны эцэст үлдэгдэлгүй байхад санхүүгийн тайлангаар 58,9 мянган төгрөгийн авлагатай гарсан байна.

**Шийдэл:** Зөвлөмж өгсөн

**Асуудал 5:** Бууцагаан сумын Цэцэрлэг нь 2018 оны 8-р сард нягтлан бодогч санхүүгийн програмд 9-р сарын орлого 518.3 мянган төгрөгийг орлого авч зарлага гаргасан байхад няравын дээрх материалыг 9-р сард орлого авч зарлагыг гаргаснаас давхардаж мөнгийг Мөнхийн хүч ХХК-д илүү шилжүүлсэн байна. Мөн 2018 оны 12-р сард харилцах данснаас цалинд 63.0 мянган төгрөгийг илүү шилжүүлж авлагаар тайланд тусгаагүй байна.

**Шийдэл:** Төлбөрийн акт тогтоосон.

**Асуудал 6:** Бууцагаан сумын Цэцэрлэг нь 2018 оны 6 сард 5 ажилтны цалин, амралтын цалингаас даатгуулагчийн төлөх НДШ-ийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцон хязгаарлалт хийснээс НДШ-ийн 212,2 мянган төгрөгийг дутуу суутгасан, их эмч Д.Оюунгэрэлд ЗГ-ын 90-р тогтоолын нэмэгдэл 54,5 мянга, багш А.Номин-Эрдэнэд шийдвэргүйгээр зэргийн нэмэгдэл 60,0 мянган төгрөгийг олгосон байна

**Шийдэл:** Төлбөрийн акт тогтоосон.

**Асуудал 7:** Бууцагаан сумын СХС-аас зээл авсан иргэдийн зээлийн гэрээ, зээлдэгчийн хувийн хэргээс зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлсөн эсэхийг тулган шалгахад 11 зээлдэгч зээлийн гэрээний үүргээ биелүүлээгүй санд 11160.5 мянган төгрөгийг төвлөрүүлээгүй байна.

**Шийдэл:** Төлбөрийн акт тогтоосон.

**Асуудал 8:** Бууцагаан сумын ЗДТГ нь Л.Болдбаатарын ндш-г 291.6 мянган төгрөгөөр дутуу мэдээлж 67.0 төгрөгийн шимтгэлийг төлөөгүй байна.

**Шийдэл:** Төлбөрийн акт тогтоосон.

**Асуудал 9:** Бууцагаан сумын ЗДТГ нь Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас 4.9 сая төгрөгийг зориулалт бусаар, 45.0 сая төгрөгийг анхан шатны баримтгүй гүйлгээ хийсэн, "Буянт богдын хишиг" хадгаламж зээлийн хоршоотой тендер зарлаагүй 15.0 сая төгрөгөөр гэрээ байгуулж 10.0 сая төгрөгийг олгосон байна.

**Шийдэл:** Зөвлөмж өгсөн

**Асуудал 10:** Бууцагаан сумын ЗДТГ нь Сургуулийн хичээлийн байр, спорт заалны халаалтын системийг шинэчлэх засварын ажлын магадалшгүй ажил, хяналтын зардал 2275.0 мянган төгрөг, байгаль орчины барьцааны мөнгөнөөс 949.3 мянган төгрөгийг зөвшөөрөлгүй зарцуулсан.

**Шийдэл:** Зөвлөмж өгсөн

2.8.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 12 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 1 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

№	Залруулгын товч утга	Мөнгөн дүн (мянган төгрөгөөр)	Тайлант хугацаанд гарсан нягтлан бодох бүртгэлийн тооцооллын алдаа
1	Аудитаар бараа материалын тайланд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 927.5 мянган төгрөгийн хөрөнгийг Э-тайланд хандив тусламжаар авсан гэж бүртгэсэн, үндсэн хөрөнгийн дансанд ЗДТГ 18000.0 мянган төгрөгийн бусад эх үүсвэрээс ирсэн хөрөнгийг дахин үнэлгээгээр нэмэгдсэн гэж тайланд тус тус буруу илэрхийлсэн байна	18927,5	тийм
	Дүн	18927,5	

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	2000,0	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	1200,0	
	Дүн	2	3200,0	

2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал:

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

**2.8.2.1 Төлбөрийн акт тогтоосон зөрчилтэй асуудал:**

Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн төвлөрсөн 23334.3 мянган төгрөгийн орлогоос шийдвэргүйгээр 1200.0 мянган төгрөгийг иргэн Хүрэлтогоогийн дансанд 2018.10.24-ны өдөр шилжүүлсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 23.8.4-т "агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж"-ийн орлогыг сумын орон нутгийн орлогод төвлөрүүлнэ, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

**2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Байхгүй

**2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Бууцагаан сумын Засаг даргын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2018 онд хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2526629,4 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 3.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 2371759,3 мянган төгрөг буюу 93,9 хувьтай 154870,0 мянган төгрөгийг хэмнэсэн байна. Энэ нь ОНХС-гаас төлөвлөсөн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлээгүйгээс 106389,7 мянга, СХС-гаас зээл олгоогүйгээс 49565,5 мянган төгрөгийг зарцуулаагүй байна.

Орон нутгийн төсөвт байгууллагууд санхүүгийн дэмжлэгээр 322571.1 мянга, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд 1828235.9 мянга, ОНХНС-аас 84435.6 мянган төгрөгийн санхүүжилт авч тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд зарцуулаагүй 4204,9 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна. СХС-гийн данс оны эхэнд 14302,4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба 60810,7 мянган төгрөгийн зээлийн эргэн төлөлтийн болон хүүгийн орлого төвлөрч, 4 зээлдэгчид 10300,0 мянган төгрөгийн зээл олгон, үйл ажиллагааны зардалд 945,3 мянган төгрөг зарцуулан оны эцэст 63867,8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

ОНХС -гийн төлөвлөгөө 234294,7 мянган төгрөгөөр батлагдаж гүйцэтгэлээр 149589,1 мянган төгрөг зарцуулан 84705,6 мянган төгрөг зарцуулаагүй байна. ОНХС-гийн данс оны эхэнд 94859,2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд ОНХНС-с 84435,6 мянган төгрөгийн санхүүжилт авч бусад орлогоор 65153,5 мянган төгрөг төвлөрч төсөл арга хэмжээнд 127905,0 мянган төгрөг зарцуулан оны эцэст 116543,2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Бууцагаан сум орон нутгийн орлогоор 97332.0 мянган төгрөг оруулж төлөвлөгөөг 158.2 хувиар буюу 35032.0 мянган төгрөгөөр давуулан биелүүсэн байна. Төсөвт байгууллагууд өөрийн орлогоор 20100,0 мянган төгрөг оруулахаар төлөвлөснөөс 24516,2 мянган төгрөгийг оруулжээ.

### **2.11. Шилэн дансны мэдээлэл**

Бууцагаан сумын Засаг даргын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

### **2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн өгөгдөөгүй байна.

### **2.13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:**

Бууцагаан сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 22127,5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэн бөгөөд харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитыг нэгтгэн нийт илэрсэн алдаа, зөрчлийн 41.0 хувь буюу 69554,8 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 8.9 хувь буюу 15147,5 мянган төгрөгийн зөрчилд

хохирлыг барагдуулах төлбөрийн акт тогтоож, 50.1 хувь буюу 84925,3 мянган төгрөгийн зөрчлийг засах, давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлээ.

Төрийн аудитын байгууллагаас аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил түүний шийдвэрлэлийн байдлыг дор нэгтгэн үзүүлэв. Үүнд:

Мянган төгрөг

№	Байгууллагын ангилал	Илрүүлэлт						Залруулга	
		Зөрчил		Алдаа		Бүгд дүн		Тоо	Дүн
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	ТТЗ	2	3200,0	1	18927,5	3	22127,5	1	18927,5
2	ТШЗ	10	96927,9	3	50627,3	13	147555,2	3	50627,3
	Дүн	12	100127,9	4	69554,8	16	169682,7	4	69554,8

### Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт

Мянган төгрөг

№	Байгууллагын ангилал	Залруулаагүй алдаа, зөрчил		Үүнээс: Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах санал		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТТЗ	2	3200,0	1	1200,0	-	-	1	2000,0	-	-	-	-
2	ТШЗ	10	96927,9	6	14002,1	-	-	4	82925,8	-	-	-	-
	Дүн	12	100127,9	7	15202,1	-	-	5	84925,8	-	-	-	-

#### 2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Бууцагаан сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Бууцагаан сумын Засаг даргын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудын хүрээний байгууллагад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн санал дүгнэлтийг нэгтгэн үзүүлэв.

Бууцагаан сумын ЗДТГ нь хөрөнгө оруулалтын зардлаар тендер зарлаагүй автомашин худалдан авах гэрээг 15,0 сая төгрөгөөр байгуулсан, хөрөнгө худалдан авахдаа нэг төрлийн арга хэмжээг хэсэгчилж гэрээ байгуулж худалдан авалт хийсэн, хөрөнгө оруулалтын зардлыг урсгал зардалд зарцуулсан, гүйцэтгэсэн горим сорилын дүнд илэрсэн алдаа, зөрчлийн дүн нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшингээс 56,9 сая төгрөгөөр давсан зэрэг зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.5, Засгийн газрын 2013 оны “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 68 дугаар тогтоол, Төсвийн тухай хуулийн 16.5.5. дэх заалтууд зөрчсөн бөгөөд “Эрх ба үүргийн”, “Үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаагүй тул 2018 оны санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн байна.

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлтийн хэлбэр (Тоогоор)				Дүн
		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан	
1	ТШЗ	6	1	-	-	7
	Дүн	6	1	-	-	7

### 3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Бууцагаан сумын Засаг дарга нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### 3.1 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

#### 3.1.1 Илрүүлэлт:

Сумын ЗДТГ-т сумын ИТХ-аар баталсан санхүүжилтээс илүү 2.0 сая төгрөгийн санхүүжилтийг Төрийн сан хууль зөрчин зарцуулах илүү эрхийг нээснээс 974.0 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 1026.2 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн.

Энэ нь Үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сумын ИТХ-ын хуралдааны 2018.01.10-01 тогтоолоор баталсан сумын ЗДТГ-ын төсөв баталсан тогтоол, Төсвийн тухай хуулийн 16.5.2 "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" тус тус зөрчсөн байна.

3.1.2 Сумдын төсөвт байгууллагуудын санхүүжилтийн эрхийг нээхдээ Төсвийн тухай хуулийн дагуу сумын ИТХ-ын хуралдаанаар баталсан санхүүжилтээс илүү санхүүжилт олгож эрх нээдэг явдлыг таслан зогсоож, ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланг хугацаанд нь үнэн зөв нэгтгэж байх. Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан Улсын төсвийн НББ-ийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв нэгтгэж байх.

#### 3.1.3 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Хүлээн зөвшөөрч байна

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 4 дүгээр сарын 20-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>629018489.60</b>	<b>718095305.68</b>
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	112878496.39	219969293.75
312	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	112878496.39	219969293.75
3121	<b>Төгрөг</b>	112878496.39	219969293.75
31211	Төрийн сангийн харилцах	112878496.39	219969293.75
33	<b>АВЛАГА</b>	216450310.00	202162966.52
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1160155.00	950169.52

Бууцагаан сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

